



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/486

Улаанбаатар хот

Япон Улсын Коосэн сургуульд
оюутан суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны Журам батлах тухай А/308 дугаар тушаалаар батлагдсан "Япон Улсад инженер, технологийн чиглэлээр Коосэн, хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам"-ын 2.7, 2.9, "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн Удирдах хорооны 2014 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн шугамаар 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн Япон Улсын Коосэн сургуульд суралцах оюутны нэрсийг хавсралт ёсоор баталсугай.


2. Коосэн сургуульд суралцах оюутантай холбогдох журмын дагуу Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Насанбаяр/, Санхүү, эдийн засгийн газар /Ц.Баярхүү/, Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус үүрэг болгосугай.



Л.ГАНТӨМӨР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2014 оны 12 дугаар сарын ...-ний өдрийн
... дугаар тушаалын хавсралт



2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС
ЯПОН УЛСЫН КООСЭН СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ОЮУТНЫ НЭРС

д/д	Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Япон Улсад суралцах сургууль	Суралцах хугацаа /он, жил/	Мэргэжлийн чиглэл
1	Энхбаатар Хангай	Кагошима Коосэн сургууль	2015-2018 он /3 жил/	Хүрээлэн буй орчин, хот төлөвлөлтийн инженерчлэл
2	Батбаяр Цогтбаатар	Сэндай Коосэн сургууль	2015-2018 он /3 жил/	Мэдээллийн сүлжээний инженерчлэл
3	Лхагвасүрэн Ганбат	Ибараки Коосэн сургууль	2015-2018 он /3 жил/	Цахилгаан электроникийн системийн инженерчлэл
4	Гантулга Батцогт	Кагава Коосэн сургууль	2015-2018 он /3 жил/	Электрон мэдээллийн инженерчлэл
5	Отгонбямба Батбанди	Мацүо Коосэн сургууль	2015-2018 он /3 жил/	Барилгын инженерчлэл
6	Амарсанаа Содномдорж	Акаши Коосэн сургууль	2015-2018 он /3 жил/	Хот төлөвлөлтийн системийн инженерчлэл